

Олон Улс Судлал №3, 2014 он: хуудас 159-160.

“Зүүн Хойт Азийн энх тайван ба хөгжил” III олон улсын хурал болов

БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай бүсэд 2014 оны 10-р сарын 14-16-ны өдрүүдэд “Зүүн Хойт Азийн энх тайван ба хөгжил” сэдэвт 3 дахь удаагийн олон улсын хурлыг БНХАУ-ын Олон улс судлалын сан (China Foundation for International Studies), Хятадын Ардын Гадаад хэргийн Хүрээлэн (Chinese People’s Institute of Foreign Affairs) зохион байгуулав.

Уг хуралд ЗХА-ийн орнууд болох Япон, БНСУ, АНУ, ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын эрдэмтэн судлаачид, элчин сайдаар ажиллаж байсан албаны хүмүүс зэрэг 80 гаруй төлөөлөгчид оролцов. Тухайлбал, ЗХА-ийн орнууд болох Япон, БНСУ, АНУ, ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын эрдэмтэн судлаачид, элчин сайдаар ажиллаж байсан албаны хүмүүс зэрэг 80 гаруй төлөөлөгчид оролцов. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Коммунист намын Төв хорооны зөвлөх, Тяньжин хотын Ардын Төлөөлөгчдийн Байнгын Хорооны дарга, зарим гишүүд, Тяньжингийн Хятадын Коммунист намын төв хорооны дэд дарга, ОХУ-ын Засгийн газрын дэд дарга асан, Төрийн Думын даргын зөвлөх С.Шахрай, БНСУ-ын Үндэсний Ассемблейн дарга асан Ким Хионг О. Гадаад хэргийн сайд асан Сөулын Их Сургуулийн профессор Ён Ианг Кван, Японы парламентын дээд танхимын гишүүн Хамада Казуики зэрэг албаны хүмүүс оролцлоо.

Монголын талаас ШУА-ын Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор А.Нямдолжин, ЭШАА доктор, профессор Н.Төмөр, МУИС-ын Олон Улсын Харилцаа, нийтийн Удирдлагын сургуулийн ахлах багш Д.Даваасамбуу (Лондонд Монгол Улсын элчин сайдаар ажиллаж байсан), ГХЯ-ны Бодлого төлөвлөлт,

ОЛОН УЛС СУДЛАЛ

судалгааны газрын Гуравдугаар нарийн бичгийн дарга Ц.Батзаяа нар оролцов.

Монголын талаас салбар хуралдаануудад 2 илтгэл тавьсан бөгөөд “Political and Security forum” сэдэвт салбар хуралдаанд доктор А.Нямдолжин “Mongolia’s approach to Security in North East Asia” сэдвээр, доктор Н.Төмөр “Regional Trade and Economic Cooperation” салбар хуралдаанд “Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв.